



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн (цаашид “Компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн бүрэн эрх, түүний гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, бүрэн эрхийн хугацаа, нэр дэвшүүлэх, сонгох журам, зөвлөлийн үйл ажиллагааны журам болон зөвлөлөөс компанийн бусад эрх бүхий этгээд, зөвлөлийн хороодтой харилцах харилцаа, мөн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө гишүүнийг чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. ТУЗ-ийн үндсэн зорилго нь компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, удирдлага зохион байгуулалт, санхүү эдийн засгийг бэхжүүлэх, компанийн цаашдын бодлого чиглэлийг тогтоох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.
- 1.3. Компани болон гишүүн хоорондын харилцааг Иргэний хуульд заасан гэрээгээр зохицуулах ба тус гэрээнд компанийн нэрийн өмнөөс хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх)-аас итгэмжлэгдэн томилогдсон этгээд гарын үсэг зурна.
- 1.4. Энэхүү Журмыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 сарын 7-ны өдрийн 162 тоот тогтоолоор баглагдсан Компанийн засаглалын кодекс, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн боловсруулав.

ХОЁР.ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХ

- 2.1. ТУЗ нь хууль болон Компанийн дүрмийн дагуу ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаас бусад компанийн гүйцэтгэх удирдлагад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.2. ТУЗ-ийн бүрэн эрхэд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:
 - 2.2.1. Гүйцэтгэх удирдлагын зөвлөмж, бэлтгэл ажлын дагуу компанийн жилийн санхүү, бизнес төлөвлөгөө зэрэг компанийн стратеги, бизнесийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;
 - 2.2.2. Компанийн урт, богино хугацааны санхүүгийн болон үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөг батлах, тэдгээрийн гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргах;
 - 2.2.3. Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх; гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх тохиолдолд гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг томилох, чөлөөлөх тэдгээрийн бүрэн эрхийг тодорхойлох;
 - 2.2.4. Салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах, тэдгээрийн дотоод журмыг батлах;
 - 2.2.5. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийг гаргах;
 - 2.2.6. Компанид хадгалж байвал зохих нэмэлт баримт бичгийн жагсаалт гаргах;
- 2.3. ХЭХ-д бэлтгэх, хурлыг зохион байгуулахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрхэд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:
 - 2.3.1. Хэрэв саналын хуудсаар урьдчилан санал авах тохиолдолд ХЭХ болох огноо, газар, эхлэх цаг, бөглөсөн саналын хуудсаа илгээх шуудангийн хаягийг тодорхойлох, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг тодорхойлох;
 - 2.3.2. ХЭХ-ын оролцогчдын нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг тодорхойлох;
 - 2.3.3. ХЭХ-ын хэлэлцэх асуудлуудыг батлах, хувьцаа эзэмшигчдийн саналыг хурлын хэлэлцэх асуудалд тусгах;
 - 2.3.4. ХЭХ хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журмыг тодорхойлох;
 - 2.3.5. ХЭХ-д бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох мэдээллийн (материал) жагсаалт гаргах, тухайн мэдээлэлтэй танилцах боломжоор хангах;



- 2.3.6. Хэрэв саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны маягт, агуулгыг батлах;
 - 2.3.7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (ХЭЭХ) болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах (ХЭЭБХ);
 - 2.3.8. Хувьцаа эзэмшигчийн ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар гаргасан санал болон Компанийн ТУЗ болон тооллогын комисст нэр дэвшүүлэх хүний талаарх саналыг хүлээн авч, хуулийн дагуу хянан үзэх;
 - 2.3.9. Хувьцаа эзэмшигч тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр санал болгосон эсэхээ үл хамааран өөр бусад асуудлыг ХЭХ-ын хэлэлцэх асуудлуудад тусгах;
 - 2.3.10. Хувьцаа эзэмшигчээс ТУЗ-ийн болон тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлээгүй буюу хангалттай тооны этгээдийг нэр дэвшүүлээгүй тохиолдолд ТУЗ болон тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх.
 - 2.3.11. Дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлана. Үүнд:
 - 2.3.11.1. ТУЗ-ийн гишүүдийн 50%-аас дээш тооны гишүүд ажиллах боломжгүй болсон;
 - 2.3.11.2. Хэрэв хоёр (2) эсвэл түүнээс дээш тооны хараат бус гишүүд, 10 болон түүнээс дээш хувийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч санал гаргасан, шаардлага тавьсан;
 - 2.3.11.3. Жилийн санхүүгийн тайлан гаргах үед Компанийн алдагдал компанийн нийт өөрийн хөрөнгийн 30%-аас давсан;
 - 2.3.11.4. Компанийн өрийн хэмжээ хоёр (2) жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
 - 2.3.11.5. ТУЗ шийдвэр гаргасан;
 - 2.3.11.6. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийх хүсэлт тавьсан;
 - 2.3.11.7. Хэрэв Компанийн ХЭХ хуульд заасны дагуу ТУЗ-д хараат бус гишүүнийг сонгоогүй, эсвэл хараат бус гишүүд нь хуульд заасан хараат бус байдлаа алдсан.
 - 2.3.12. ХЭХ-ын ээлжит бус хурлын саналыг авч үзэх, хурал зарлах хүсэлт хүлээн авсны дараа ажлын арван (10) хоногийн дотор ХЭХ зарлах эсвэл зарлах үйл ажиллагаанаас татгалзах шийдвэр гаргах;
 - 2.3.13. ХЭХ-ын ээлжит бус хурал зарлах, зарлахаас татгалзсан шийдвэрийг сонирхсон талуудад нэн даруй мэдэгдэх;
 - 2.3.14. Хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдэд хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичигтэй танилцах боломжоор хангана.
 - 2.3.15. Дараах асуудлуудыг ХЭХ-д оруулж хэлэлцүүлнэ. Үүнд:
 - 2.3.15.1. Компанийг өөрчлөн байгуулах, өөрчлөн байгуулалтын хэлбэр болон холбогдох асуудлууд;
 - 2.3.15.2. Компанийг татан буулгах, татан буулгах комисс байгуулах, холбогдох бичиг баримтыг батлах;
 - 2.3.15.3. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн тодорхой асуудлыг хөндлөнгийн менежерт шилжүүлэх;
 - 2.3.15.4. Жилийн тайлан батлах;
 - 2.3.15.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;
 - 2.3.15.6. Хувьцааг хуваах, нэгтгэх;
 - 2.3.15.7. Нийт гишүүд нь тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй байх, эсвэл тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүд дотор нь хараат бус гишүүд байхгүй байгаагаас шалтгаалан сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах боломжгүй болсон үед тухайн хэлцлийг батлах эсэхийг шийдүүлэхээр;
 - 2.3.15.8. Компани өөрийн хувьцааг худалдаж авах;
 - 2.3.15.9. ТУЗ, ХЭХ-ын дотоод дүрмийг батлах;
 - 2.3.15.10. ТУЗ-ийн гишүүдийн ажлын хөлсийг батлах.
- 2.4. Компанийн үнэт цаас, үндсэн хөрөнгөтэй холбоотой ТУЗ-ийн бүрэн эрхэд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:



- 2.4.1. Энгийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа, өрийн бичиг, опцион гэх мэт үнэт цаасанд хөрвөх чадвартай хувьцаанаас гаргах талаар шийдвэр гаргах;
- 2.4.2. Өрийн бичиг гаргах шийдвэрт заасан бол гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авах талаар шийдвэр гаргах;
- 2.4.3. Үндсэн хөрөнгийн үнэлгээг тогтоох, гаргах үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг тогтоох;
- 2.4.4. Хэрэв ХЭХ-ын хэлэлцэх асуудалд нэмэлт хувьцаа гаргах, хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх зэрэг асуудал тусгагдсан тохиолдолд, хувьцааны төлбөрт төлж болох үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, энэ төрлийн үндсэн хөрөнгийн үнэлгээний тайлан гаргах;
- 2.4.5. Ногдол ашгийн төлбөрийн хэмжээг тогтоож, ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулах;
- 2.4.6. Компанийн нөөц хөрөнгө болон бусад мөнгөн хөрөнгийг ашиглах асуудлыг шийдвэрлэх;
- 2.4.7. Хуульд заасан тохиолдолд их хэмжээний хэлцэл бол бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй тусгай хэлцлийг батлах;
- 2.4.8. Компанийн цэвэр ашгийн 10%-аас дээш үнэтэй хөрөнгөтэй холбогдох гэрээ, хэлцлийг батлах;
- 2.4.9. Нийт гишүүд нь тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй байх, эсвэл тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүд дотор нь хараат бус гишүүд байхгүй бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах эсэхийг шийдэх;
- 2.4.10. Санхүү болон бизнесийн төлөвлөгөөнөөс гадна үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах (стандарт бус бизнесийн үйл ажиллагаа).
- 2.5. Компанийн гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх, хянахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрхэд дараах үйл ажиллагаа хамарна. Үүнд:
 - 2.5.1. Байнгын болон түр ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах;
 - 2.5.2. Компанийг төлөөлөн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ТУЗ-н нарийн бичгийн даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулах, эсвэл бусад албан тушаалтанд компанийг төлөөлөн гэрээ байгуулах эрх олгох;
 - 2.5.3. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн ажлын хөлсийг оролцуулан хөдөлмөрийн гэрээний нөхцөлүүдийг тодорхойлох;
 - 2.5.4. Хөндлөнгийн аудитор томилох, түдгэлзүүлэх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлүүдийг тодорхойлох;
 - 2.5.5. Гүйцэтгэх захирлын өөр компанийн удирдах албанд ажиллах асуудлыг зөвшилцөх;
 - 2.5.6. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийж, тусгай шалгалт явуулах хүсэлт гаргах;
 - 2.5.7. Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас аман болон бичгээр үйлдсэн тайлан, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримт, мэдээлэл авах хүсэлт тавих;
 - 2.5.8. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх;
 - 2.5.9. Дараах дотоод журмуудыг батална. Үүнд:
 - 2.5.10.1. Гүйцэтгэх захиралд холбогдох;
 - 2.5.10.2. Эрсдэлийн менежмент;
 - 2.5.10.3. Мэдээллийн бодлого;
 - 2.5.10.4. ТУЗ-ийн нарийн бичигт холбогдох;
 - 2.5.10.5. Нууцлалын болон дотоод мэдээлэл;
 - 2.5.10.6. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын журам;
 - 2.5.10.7. Засаглалын бодлого;
 - 2.5.10.8. Компанийн ХЭХ болон гүйцэтгэх удирдлага баталснаас бусад дотоод баримт бичиг;
 - 2.5.10.9. Хуульд заасан бусад дүрэм журам



- 2.6. Гишүүд нь Компанийн гүйцэтгэх удирдлага, Компанийн бүтэц, нэгжийн дарга нараас өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл авах эрхтэй.
- 2.7. ТУЗ-ийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудлуудыг гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багт шилжүүлэхгүй.

ГУРАВ. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 3.1. ТУЗ нь 9-өөс доошгүй гишүүдээс бүрдэх ба нийт гишүүдийн гуравны нэгээс багагүй тооны гишүүд хараат бус байна.
- 3.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь хувь хүн байна. Компанийн хувьцаа эзэмшигч биш этгээдийг гишүүнээр сонгож болно.
- 3.3. Компанийн ТУЗ-д сонгогдсон хүмүүсийг улируулан сонгож болно.
- 3.4. ТУЗ-ийн гишүүн нь аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, дадлага туршлага бүхий ёс зүйн өндөр шаардлага хангасан байвал зохино.
- 3.5. ТУЗ-ийн гишүүн нь өрсөлдөгч Компанийн хувь нийлүүлэгч, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ажилтан байж болохгүй.
- 3.6. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн, бизнес, санхүү, татвар, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргасан болох нь тогтоогдож шийтгэл хүлээсэн этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохгүй.
- 3.7. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албан тушаалд гишүүнээр ажиллаж байгаа хүнийг томилохгүй.
- 3.8. Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс ТУЗ-д ажиллах гишүүдийн тоо нь ТУЗ-ийн гишүүдийн дөрөвний нэгээс илүү байж болохгүй.
- 3.9. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг заавал хангасан байна.
- 3.10. ТУЗ болон гишүүн бүрийн ажлын гүйцэтгэлийг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны зөвлөмжид үндэслэн ТУЗ-өөс боловсруулсан тавигдах шаардлагын дагуу үнэлнэ.

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРИУЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ-ийн дарга:

- 4.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дундаас ил санал хураалтаар сонгох ба олонхын санал авсан дүнгээр ТУЗ-ийн даргыг томилох, чөлөөлөх, дахин сонгох эрхтэй.
- 4.2. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдах бөгөөд гишүүдийн санал хурлын үеэр тэнцсэн тохиолдолд тухайн асуудлыг өөрийн саналаар шийдвэрлэх давуу эрх эдэлнэ.
- 4.3. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнээр ажиллаж байгаа нэр дэвшигчийг ТУЗ-ийн даргаар сонгохгүй.
- 4.4. ТУЗ-ийн дарга дараах үйл ажиллагааг хариуцна:
 - 4.4.1. ТУЗ-ийн ажлыг зохион байгуулах, нийт гишүүдийг санал бодлоо чөлөөтэй солилцох нөхцөлөөр хангах, хэлэлцэх асуудлуудаар нээлттэй хэлэлцүүлэг явуулах;
 - 4.4.2. ТУЗ-ийн уулзалтын хуваарь гаргаж, зохион байгуулах, хурлаар хэлэлцэх асуудлуудыг бэлтгэх, гишүүдийн зөвшөөрлийн бичигт үндэслэн санал хураалт явуулах;
 - 4.4.3. Хурлын тэмдэглэл хөтлүүлэх, тэмдэглэлд гарын үсэг зурах;
 - 4.4.4. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчтэй холбогдуулан тухайн нэр дэвшигчид эрүүгийн гэмт хэргийн улмаас ял шийтгүүлсэн эсэх талаар мэдээлэл авах хүсэлт гаргах;
 - 4.4.5. Компанийг төлөөлөн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй байгуулах гэрээнд гарын үсэг зурах;
 - 4.4.6. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлуудын талаарх материалыг бүрдүүлэх, хурлын дэгийн дагуу санал хурааж үр дүнтэй шийдвэр гаргах;
 - 4.4.7. Хурлаас долоо хоногаос доошгүй хугацааны өмнө гишүүдийг хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээллээр хангах;



- 4.4.8. ТУЗ-ийн хороонуудыг байгуулах ажлыг зохион байгуулах, тус хороонуудад гишүүдийг нэр дэвшүүлэх, Компанийн ажилтан, гишүүд, хороодын хоорондын харилцааг зохицуулах;
- 4.4.9. Гүйцэтгэх захирал болон бусад удирдах ажилтнуудтай байнгын харилцаа холбоотой ажиллах;
- 4.4.10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах талаар хувьцаа эзэмшигчийн бичгээр гаргасан санал хүлээн авах;
- 4.4.11. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнд нэр дэвшүүлэх;
- 4.4.12. ХЭХ-ыг өөр албан тушаалтан зарлаж, ХЭХ-ийг даргалах өөр этгээдийг томилсноос бусад тохиолдолд ХЭХ-ыг даргалах;
- 4.4.13. Компанийн жилийн тайланд тусгах тухайн жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэх.
- 4.5. ТУЗ-ийн даргын эзгүй үед түүний томилсон гишүүн хурлыг удирдана. ТУЗ-ийн дарга аливаа этгээдийг томилоогүй бол хамгийн ахмад гишүүн хурлыг удирдана.

ТУЗ-ийн гишүүн:

- 4.6. ТУЗ-ийн гишүүд эрх, үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.6.1. Шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга хандаж, компани болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллана. Өөрөөр хэлбэл бүх боломжит мэдээллийг анхаарч үзэх, ойролцоо нөхцөл байдалд анхааралтай, сайтар бодож боловсруулсан шийдвэр гаргах;
 - 4.6.2. Зарлагдсан хурлуудад оролцох, сонгогдсон ТУЗ-ийн хороодынхоо ажилд оролцох;
 - 4.6.3. Тодорхой бус, ойлгомжгүй асуудлуудын талаар тодруулга хийж, асуулт тавих;
 - 4.6.4. ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй шалтгаанаа ТУЗ-д урьдчилан мэдэгдэнэ.
 - 4.6.5. ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд биечлэн оролцох, түүний биелэлтийн талаар мэдээлэл авах, ТУЗ-ийн эрх хэмжээний асуудлаар хяналт шалгалт явуулна.
 - 4.6.6. ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох хүмүүст шаардлага тавих, тайлбар гаргуулах, хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх, үндэслэл гаргах, шийдвэр батлуулах зэрэг бүрэн эрхтэй.
- 4.7. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааг тусгайлсан журмаар зохицуулна.

ТАВ. ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

- 5.1. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 2 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх хэрэгжинэ.
- 5.2. Өмнөх ТУЗ-ийн бүрэн эрх дараагийн ТУЗ томилогдоход дуусгавар болно.
- 5.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаанд хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн ХЭХ-г бэлтгэх, түүнийг зарлах, зохион байгуулахаас бусад Компанийн тухай хууль болон энэ дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.
- 5.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эрхтэй.
- 5.5. Хэрэв гишүүн удаан хугацаагаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон, ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан бол ТУЗ-өөс орлох хүнийг ХЭХ-ийн ээлжит бус хурлаар түр томилж болно.

ЗУРГАА. НЭР ДЭВШҮҮЛЭХ

- 6.1. Санал гаргах өдөр саналын эрх бүхий хувьцааны хамгийн багадаа 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
- 6.2. Гүйцэтгэх захирал санхүүгийн жил дууссанаас хойш жар (60) хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн эзэмшигчдийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай саналыг хүлээж авна.
- 6.3. ТУЗ нь ТУЗ-ийн гишүүнд тодорхой этгээдийг нэр дэвшүүлэх эрхтэй.
- 6.4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн эзэлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана.
- 6.5. Нэр дэвшүүлэх саналыг бичгээр үйлдэх ба дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:



- 6.5.1. Санал болгосон нэр дэвшигч бүрийн эцгийн нэр, өөрийн нэр;
- 6.5.2. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн эцгийн нэр, өөрийн нэр;
- 6.5.3. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоо, төрөл, ангилал;
- 6.5.4. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн гарын үсэг;
- 6.5.5. Энэхүү журмын 6.4 дүгээр заалтад заасан мэдээлэл.
- 6.6. Тухайн саналд хувьцаа эзэмшигч эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хавсаргана.
- 6.7. ТУЗ гаргасан саналыг нягталж үзэх ба тухайн саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор нэр дэвшигчийг ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.
- 6.8. Нэр дэвшигчийг жагсаалтад оруулахаас татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг холбогдох бичиг баримтын хамт тухайн шийдвэрийг гаргаснаас хойш ажлын гурав (3) өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.
- 6.9. Дараахаас бусад тохиолдолд нэр дэвшигчдийг жагсаалтад оруулна. Үүнд:
 - 6.9.1. Хувьцаа эзэмшигч энэ зүйлийн 6.2 дугаар заалтад тусгасан хугацааг дагаж мөрдөөгүй;
 - 6.9.2. Хувьцаа эзэмшигч энэ зүйлийн 6.1 дүгээр заалтад заасан тооны саналын эрхтэй хувьцааг эзэмшдэггүй;
 - 6.9.3. Гаргасан санал энэхүү Журмын 6.5 дугаар заалтад тусгасан шаардлагыг хангаагүй;
 - 6.9.4. ХЭХ-ын хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар санал болгосон асуудал ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарахгүй.
- 6.10. ТУЗ-д нэр дэвшигч хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулахаас өмнө нэрээ татаж авах эрхтэй.
- 6.11. Нэр дэвшүүлэх хороо нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдийг шалгаруулж, нэр дэвшүүлэх бөгөөд дараах баримтыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна. Үүнд:
 - 6.11.1. Хараат бус гишүүнд нэр дэвших этгээдийн тодорхойлолт;
 - 6.11.2. Хараат бус гишүүнд нэр дэвших этгээдийн мэдүүлэг;
 - 6.11.3. Хараат бус гэдгийг нотлох мэдээлэл, уг мэдээлэл үнэн зөв болох тухай нэр дэвшигчийн баталгаа;
 - 6.11.4. Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
 - 6.11.5. Эрүүгийн хариуцлага, ял шийтгэл хүлээж байсан эсэх, хүлээж байгаа эсэх тодорхойлолт, лавлагаа;
 - 6.11.6. Боловсролын гэрчилгээ, дипломыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
 - 6.11.7. Хараат бус гишүүний ажил үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил, саад байгаа эсэх.

ДОЛОО. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТҮҮНИЙГ СОНГОХ БА ЧӨЛӨӨЛӨХ

- 7.1. ТУЗ-ийн гишүүд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 7.1.1. Иргэний эрх зүйн бүрэн чадвар, чадамжтай байх;
 - 7.1.2. Санхүү, бизнесийн зохих түвшний мэдлэгтэй байх;
 - 7.1.3. Компанийн тухай хууль тогтоомж, болон холбогдох бусад хууль, эрх зүйн акт, дүрмээр тогтоосон үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, боловсрол эзэмшсэн байх;
 - 7.1.4. ТУЗ-ийн гишүүнээр ажиллах дадлага, туршлагатай Монгол Улсын болон гадаад улсын иргэн байх.
- 7.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 7.2.1. Ёс зүйн хэм хэмжээг сахих;
 - 7.2.2. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, мэргэшсэн байх;
 - 7.2.3. Компанийн засаглалын цаашдын хөгжилд өөрийн туршлага, мэдлэгээ зориулах хүсэл, чадвартай, цаг заваа зарцуулдаг байх;
 - 7.2.4. Харилцааны ур чадвартай байх;
 - 7.2.5. Аливаа асуудалд дүн шинжилгээ хийх чадвартай, бие даасан байх.



7.3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох

- 7.3.1. Энэхүү журмын 6.1 дүгээр заалтад тусгаснаар санал болгосон болон нээлттэй сонгон шалгаруултаар ТУЗ-ийн гишүүн болох хүсэлтэй журмын 6.4, 6.5 дугаар заалтад заасан шаардлагыг хангасан иргэнийг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж, сонгоно.
- 7.3.2. Нэр дэвшүүлэх хороо нь хараат бус гишүүнд нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага нь компанийн дүрэм, Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлж, сонгоно.
- 7.3.3. Гишүүдийг кумулятив (сонгогч хэд хэдэн саналыг нэр дэвшигчийн тоогоор өгч дараа нь хуваах сонгуулийн зарчим) аргаар сонгоно.
- 7.3.4. Сонгуулийг кумулятив аргаар явуулахад хувьцаа эзэмшигч өөрийн саналаа нэг нэр дэвшигчид өгөх эсвэл өөрийн сонгосон нэр дэвшигчдийн дунд хуваарилж болно.
- 7.3.5. Хамгийн олон тооны санал авсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсонд тооцно.
- 7.3.6. ТУЗ-ийн сонгуультай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийг дараах мэдээллээр хангана. Үүнд:
- 7.3.6.1. Нэр дэвшигчийг санал болгож буй хувьцаа эзэмшигч буюу хэд хэдэн хувьцаа эзэмшигч;
- 7.3.6.2. Нэр дэвшигч;
- 7.3.6.3. Нэр дэвшигчийн нас, боловсрол;
- 7.3.6.4. Өнгөрсөн таван (5) жилд эрхэлсэн ажлыг нь оролцуулан мэргэжлийн туршлага;
- 7.3.6.5. Нэр дэвших үедээ хашиж буй ажил, албан тушаал;
- 7.3.6.6. Нэр дэвшигчийн Компанитай холбогдсон байдал;
- 7.3.6.7. Нэр дэвшигчийн бусад аж ахуйн нэгжид хашиж буй удирдах болон бусад албан тушаалууд;
- 7.3.6.8. Бусад аж ахуйн нэгжийн захирал, бусад албан тушаалд нэр дэвшсэн байдал;
- 7.3.6.9. Нэр дэвшигчийн Компанийн охин, хараат компаниудтай холбогдсон байдал;
- 7.3.6.10. Нэр дэвшигч болон Компанийн голлох гүйцэтгэгч, гэрээлэгчийн хоорондын харилцаа;
- 7.3.6.11. Нэр дэвшигчийг зөвлөлийн гишүүнээр ажиллахад нөлөө үзүүлэхүйц байдал, бусад нөхцөл байдал;
- 7.3.6.12. Нэр дэвшигчийн зүгээс Компанийн хүссэн мэдээллийг өгөхөөс татгалзсан байдал.
- 7.3.7. ТУЗ-ийн гишүүнийг улируулан томилох асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхдээ гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үнэлгээ зэрэг мэдээллийг танилцуулна.

7.4. ТУЗ-ийн даргыг сонгох

- 7.4.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ын гишүүдээс нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.
- 7.4.2. ТУЗ-ийн дарга нь компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд байж болохгүй.
- 7.4.3. ТУЗ-ийн даргын бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ын бүрэн эрхийн хугацаатай ижил байна. ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ын даргаар хэдэн ч удаа томилогдож болно.
- 7.4.4. ТУЗ-ын даргыг түр эзгүйд түүнийг ТУЗ-ын хурлаас томилсон гишүүн гүйцэтгэнэ.

7.5. ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх

- 7.5.1. ТУЗ-ийн гишүүн дараах тохиолдолд үүрэгт ажилаасаа чөлөөлөгдөнө. Үүнд:
- 7.5.1.1. Чөлөөлөгдөх хүсэлт гаргасан /хүсэлтээ нэг сараас доошгүй хугацааны өмнө ТУЗ-д бичгээр мэдэгдэнэ/;
- 7.5.1.2. Удаан хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон
- 7.5.1.3. ТУЗ-ийн гишүүн нас барсан;
- 7.5.1.4. ТУЗ-ийн гишүүний ажил үүргийг хэрэгжүүлэх боломжгүй албан тушаалд томилогдсон.



- 7.5.2. Энэхүү журмын 7.5.1 дэх хэсэгт үндэслэн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх хугацаанд нөхөн сонгох гишүүний нэрийг дэвшүүлэх асуудлыг нэр дэвшүүлэх хороо гүйцэтгэснээр ТУЗ-ийн дараагийн сонгууль хүртэл нөхөн томилно.
- 7.5.3. ХЭХ-аас ТУЗ-ийн бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 7.5.4. Хэрэв ТУЗ-ийн гишүүдийн 50-аас илүү хувь нь ажиллах боломжгүй бол ТУЗ-өөс шинэ ТУЗ байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах шийдвэр гаргах ба ийнхүү гаргахаас өөр бусад шийдвэр гаргах эрхгүй.

НАЙМ. АЖЛЫН ХӨЛС

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрт үндэслэн гишүүдэд ТУЗ, ТУЗ-ийн хороодын гишүүний үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардлын нөхөн төлбөр, мөн ажлын хөлсийг ажиллах хугацаанд нь олгоно.
- 8.2. Компанийн гүйцэтгэх удирдлагад ажилладаг гишүүд ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа бол нэмэлт цалин хөлс олгохгүй.

ЕС. ТУЗ-ИЙН ХУРАЛ

- 9.1. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга өөрийн санаачилгаар улирал бүр зарлан хуралдуулах ба дараах албан тушаалтны саналын дагуу хуралдуулж болно. Үүнд:
 - 9.1.1. ТУЗ-ийн гишүүн;
 - 9.1.2. Компанийн гүйцэтгэх захирал;
- 9.2. ТУЗ-ийн хурал хуралдуулах саналыг бичгээр үйлдэж Компани руу баталгаат шуудангаар илгээх эсвэл Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 9.3. ТУЗ-ийн хурал хуралдуулах санал гаргасан огноог Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын хүсэлт хүлээн авсан өдрөөр тодорхойлно.
- 9.4. Хурал хуралдуулах санал гаргасан хүн тухайн саналдаа гарын үсэг зурна.
- 9.5. Саналд дараах зүйлүүдийг дурдана. Үүнд:
 - 9.5.1. Хурал хуралдуулах санал гаргасан хүний нэр;
 - 9.5.2. Хэлэлцэх асуудлууд;
 - 9.5.3. Хурлын төрөл.
- 9.6. Хүсэлт хүлээн авснаас хойш арав хоногийн дотор ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулна.
- 9.7. ТУЗ-ийн дарга хурал зарлахаас үндэслэлгүйгээр татгалзсан эсвэл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй бол, ТУЗ-ийн бусад гишүүн тус хурлыг зарлаж болно.
- 9.8. ТУЗ-ийн хурал болох огноо, газар, эхлэх цаг, хэлэлцэх асуудлын талаарх мэдэгдэл, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой болон хуралд бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг ТУЗ-ийн гишүүн тус бүрд болон энэ дүрмийн 9.1-т заасан хурал хуралдуулах санал гаргасан этгээдэд баталгаат шуудан, мэйл хаяг эсвэл биечлэн хүргэх байдлаар хурал болохоос 3-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэнэ.
- 9.9. ТУЗ-ийн анхны хурлыг ТУЗ-ийг сонгосноос хойш нэг сарын дотор хуралдуулах бөгөөд энэ хурлаар ТУЗ-ийн даргыг сонгоно.
- 9.10. ТУЗ-ийн хуралд ТУЗ-ийн нарийн бичиг болон бусад холбогдох албан тушаалтнуудын бэлтгэж оруулсан ирсэн дараах мэдээллийг мэдээллийг танилцуулна. (ТУЗ-ийн хурлын материал)
 - 9.10.1. Гүйцэтгэх удирдлагын зүгээс оруулж ирж байгаа материал нь Компанийн үйл ажиллагаанд тулгарч байгаа үндсэн асуудал, учрах гол эрсдэлүүд болон түүнийг бууруулах арга хэмжээ, холбогдох арга хэмжээг аваагүй тохиолдолд үүсэх үр дагавар, хохирлыг хамарсан дүгнэлтийг багтаасан байна.
 - 9.10.2. ТУЗ-ийн хурлын материалд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:
 - 9.10.2.1. Гүйцэтгэх захирлын боловсруулсан Компанийн голлох санхүүгийн болон санхүүгийн бус гүйцэтгэлийн үзүүлэлтүүд;
 - 9.10.2.2. Санхүүгийн мэдээллийн иж бүрдэл баримт бичиг;



- 9.10.2.3. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, зөвлөмж;
 - 9.10.2.4. Маркетинг болон худалдааны тоо баримт;
 - 9.10.2.5. Бүтээгдэхүүний талаарх мэдээ;
 - 9.10.2.6. Дотоод аудиторын тайлан;
- 9.11. ТУЗ-ийн хурлын ирц гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналын дагуу гаргана.
 - 9.12. Хурал дээр санал хураалт явуулах үед гишүүн тус бүр нэг саналын эрхтэй байна.
 - 9.13. ТУЗ-ийн нэг гишүүний саналын эрхийг нөгөө гишүүнд шилжүүлэх, саналын эрхийг өөр хүнд итгэмжлэлээр дамжуулах үйл ажиллагааг зөвшөөрөхгүй.
 - 9.14. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах шийдвэрийг хуульд заасан хоорондоо ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналын дагуу гаргана. Нийт гишүүд тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй, эсвэл шийдвэр гаргах гишүүд дотор хараат бус гишүүн байхгүй тохиолдолд ХЭХ-аас дээрх хэлцлийг батлах шийдвэр гаргана.
 - 9.15. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй байгуулах гэрээний нөхцөлийг батлах шийдвэрийг санал хураалтад оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналын дагуу гаргана. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд энэ төрлийн асуудлаарх санал хураалтад оролцохгүй.
 - 9.16. Хуралд оролцоогүй ч бичгээр саналаа гаргасан гишүүдийн саналыг хурлыг ирц бүрдэлт болон санал хураалтын дүн гаргахад тооцож үзнэ.
 - 9.17. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга саналын хуудсаар хуралд оролцсон гишүүдийн санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэлийг хөтөлнө.

АРАВ. ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

- 10.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэлийг хөтөлнө.
- 10.2. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хурал дууссанаас хойш гурван (3) өдрийн дотор үйлдэнэ. Хурлын протокол дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:
 - 10.2.1. Компанийн албан ёсны нэр ба хаяг;
 - 10.2.2. Хурал болох газар (хаяг), эхлэх цаг;
 - 10.2.3. Хурлын хэлэлцэх асуудал;
 - 10.2.4. Хуралд оролцож байгаа оролцогчид болон хурлын ирцийн тоо;
 - 10.2.5. Хуралд биечлэн оролцоогүй боловч бичгээр саналаа өгсөн гишүүд;
 - 10.2.6. Санал хураасан асуудлууд, санал хураалтын дүн;
- 10.3. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл дээр тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцсан ТУЗ-ийн дарга, хуралд оролцсон нийт гишүүд, Компанийн ТУЗ-ийн нарийн бичиг гарын үсэг зурна.
- 10.4. Гишүүдийн бичгээр гаргасан саналуудыг тэмдэглэлд хавсаргана.
- 10.5. Саналын хуудсаар хураасан санал, саналын дүнгийн талаар тэмдэглэлийг саналын хуудас хүлээн авах эцсийн өдрөөс хойш гурван (3) хоногийн үйлдэх ба тэмдэглэлд ТУЗ-ийн дарга, нарийн бичиг гарын үсэг зурна.
- 10.6. Эрх бүхий этгээд ТУЗ-ийн хурлын тэмдэглэлтэй ТУЗ-ийн даргын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу танилцаж болно.
- 10.7. Компани ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг Компанийн байрандаа хадгална.

АРВАН НЭГ. ТУЗ-ИЙН ХОРООД

- 11.1. ТУЗ урьдчилсан хэлэлцүүлэг хийх, зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хамгийн чухал асуудлуудыг хэлэлцэх түр эсвэл байнгын хороод байгуулна.
- 11.2. ТУЗ нь дараах хороодыг байгуулна. Үүнд:
 - 11.2.1. Аудитын хороо
 - 11.2.2. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
 - 11.2.3. Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалт, зээлийн хороо
- 11.3. ТУЗ-ийн нэг гишүүн хоёр ба түүнээс дээш хорооны гишүүнээр ажиллахгүй.
- 11.4. Хороод шинжээч, мэргэжилтнүүд авч ажиллуулж болох ба тэдгээрийн ажлын хөлсийг тодорхойлно.



- 11.5. Хорооны хурлыг хорооны дарга, хорооны гишүүн, мөн Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хуралдуулна.
- 11.6. Асуудал хэлэлцэх хорооны хэлэлцүүлгийн дүнг хуралд оролцсон бүх гишүүдийн гарын үсэг зурж бичгээр гаргасан шийдвэрт тусгаж, ТУЗ-ийн даргад танилцуулна.
- 11.7. Хорооны гаргасан саналууд нь ТУЗ-ийн хувьд зөвлөмжийн чанартай.
- 11.8. Бусад асуудлуудыг хороодын тусгай дотоод журмын дагуу зохицуулна.

АРВАН ХОЁР. ТУЗ-ИЙН МӨРДӨХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нь ёс зүйн дараах нийтлэг зарчмыг мөрдөнө:

- 12.1. Ажил үүргээ гүйцэтгэхдээ Компанийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, аливаа шударга бус байдлаас ангид байж ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийж ажиллана.
- 12.2. Өөрийн үйл ажиллагаа, зан байдалдаа хяналт тавьж Компанийн ажилтнууд болон бизнесийн хамтрагчдын Компанид итгэх итгэл, үнэлэх үнэлэмжид эерэгээр нөлөөлж, үлгэр жишээ болохуйц биеэ авч явах ёстой.
- 12.3. Аливаа гэрээ хэлцэл, гүйлгээ хийхдээ Компаниас бизнесийн өндөр ёс зүй, хувь хүний шударга зарчимч байдлыг баримтлан ажиллана.
- 12.4. Хамтрагчид болон хамтран ажиллагсадтайгаа адил тэгш, үнэнч, шударга, ёс зүйтэйгээр харилцана. Бусад хүмүүсийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, үүсэл, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг цээрлэнэ.
- 12.5. Өөрийн эрхэлж буй албан тушаалыг ашиглан Компанийн мэдээлэл, эд хөрөнгийг өөрийн болон бусдын ашиг хонжооны төлөө зүй бусаар ашиглах ёсгүй ба Компанитай шууд болон шууд бусаар өрсөлдөх ёсгүй.
- 12.6. ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нь дараах ашиг, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын дагуу ажиллана. Үүнд:
 - 12.6.1. Компани, түүний салбар компанид мэргэжлийн хөрөнгө оруулалт оруулах гэх мэт аливаа үйл ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй (шууд болон шууд бус) байдал байгаа бол энэ талаар Компанид нэн даруй бичгээр мэдэгдэх;
 - 12.6.2. Албан тушаалын эрх мэдлийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагааны шагнал эсвэл шагналд тооцогдохоор ямар нэгэн бэлэг, үйлчилгээ, давуу байдлыг бусдаас олж авахгүй байх;
 - 12.6.3. Албан үүргээ гүйцэтгэх үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөлөгдсөний дараах гурван (3) жилийн турш задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх;
 - 12.6.4. ТУЗ-ийн хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Хэрэв нөхцөл байдал байдалд өөрчлөлт орсны улмаас хараат бус гишүүн хараат бус байх боломжгүй болсон бол тухайн гишүүн энэ талаар ТУЗ-д бичгээр нэн даруй мэдэгдэнэ.
- 12.7. Энэхүү Журмын 12.6-д заасан нөхцөлийг зөрчсөн гишүүд өөрсдийн буруутай үйл ажиллагаа, албан үүргээ биелүүлээгүйгээс үүдэн Компанид учирсан хохиролд хариуцлага хүлээнэ.
- 12.8. Компанид алдагдал учруулах шийдвэрийн эсрэг санал гаргасан эсвэл санал хураалтад оролцоогүй гишүүд учирсан хохиролд хариуцлага хүлээхгүй.
- 12.9. Гишүүдэд хариуцлага ногдуулахдаа гэм буруугийн хэмжээ, бусад холбогдох нөхцөл байдлыг харгалзан үзнэ.